үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Тайлант онд тус албанаас тайлант онд хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккрузл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхтэй холбоотой Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна..

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,369.4 сая төгрөгөөр буюу 24.3 хувиар өссөн байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	264.3	501.1	236.8
Авлага	186.9	190.6	3.7
Бараа материал	3.0	3.1	0.1
Үндсэн хөрөнгө	647.3	674.6	27.3
Нийт хөрөнгө	1,101.5	1,369.4	267.9
Өр төлбөр	24.0	9.8	(14.2)

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,077.5	1,359.6	282.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,101.5	1,369.4	267.9

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Судалгаанаас мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансдад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 501.1 сая төгрөг болж, өмнөх оноос 236.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	264.3	501.1	236.8
Төгрөг	264.3	501.1	236.8
Төрийн сангийн харилцах	264.3	501.1	236.8
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Дүн	264.3	501.1	236.8

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө данс оны эхний үлдэгдэлтэй 236.8 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлогын данс, ОНХС, ХХС-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой, байна. Орон нутгийн ерөнхий орлогын данс 91.2 сая төгрөгийн, ОНХС-гийн данс 295.7 сая төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сангийн данс 114.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Мөнгөн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 190.6 сая төгрөг болж, өмнөх оноос 3.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	3.2	3.3	0.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-	-
Татаас, санхүүжилтийн авлага	3.4	3.4	-
Зээлийн хүүгийн авлага	-	-	-
Татаас, санхүүжилтийн авлага			-
Байгууллагаас авах авлага			-
Хувь хүмүүсээс авах авлага	180.3	183.8	3.6
Дүн	186.9	190.6	3.7

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 3.7 сая төгрөгөөр өссөн нь хувь хүмүүсээс авах авлага 3.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгосон, сумын ИТХ-

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ын ажиллагсадтай холбоотой авлага 0.1 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант онд ХХС-гийн эргэн төлөлтөөс 64.0 сая төгрөгийн зээл олгосон байна.

Аудитын илрүүлэлт:

- *Авлага данстай холбоотой зөрчил гараагүй.*

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 3.1 сая төгрөг болж, өмнөх оноос 0.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн материал	3.0	3.1	0.1
Бичиг хэргийн материал	0.2	0.2	0.1
Сэлбэг хэрэгсэл	1.1	1.1	-
Түлш, шатах тослох материал	1.1	1.1	0.0
Бусад хангамжийн материал	-	-	-
Мал амьтад	0.8	0.8	-
Дүн	3.0	3.1	0.1

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Бараа материалын данс 0.1 сая төгрөгөөр өссөн нь сумын ЗДТГ-ын бичиг хэргийн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материал данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө:

Нөөцийн бараа оны эхэн, эцэст үлдэгдэлгүй.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,247.6 сая төгрөг болж, өмнөх оноос 46.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	624.9	647.8	22.9
Барилга, байгууламж, орон сууц	416.3	418.8	2.6
Авто-тээврийн хэрэгсэл	25.9	31.3	5.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	38.1	39.8	1.7

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тавилга, аж ахуйн эд хогшил	7.2	7.4	0.2
Зам, гүүрийн байгууламж	5.8	5.8	-
Бусад үндсэн хөрөнгө	131.3	144.4	13.1
Ном	0.3	0.3	-
Биет бус хөрөнгө	22.4	26.8	4.4
Программ хангамж	-	-	-
Бусад биет бус хөрөнгө	22.4	26.8	4.4
Дүн	647.3	674.6	27.3

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Үндсэн хөрөнгийн данс 27.3 сая төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгө болон аймаг, сумын ОНХС-гийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар үндсэн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 9.8 сая төгрөг болж, өмнөх оноос 14.2 сая төгрөгөөр буурсан байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	5.1	1.2	(3.9)
Ажилчидтай холбогдсон өглөг	5.1	1.2	(3.9)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-	-
Бусад өглөг	18.9	8.6	(10.3)
Байгууллагад төлөх өглөг	18.9	8.6	(10.3)
Хувь хүмүүст төлөх өглөг	-	-	-
Дүн	24.0	9.8	(14.2)

Өглөгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 14.2 сая төгрөгөөр буурсан нь ОНХС 3.1 сая, сумын ЗДТГ 11.5 сая төгрөгөөр өглөгөө бууруулж, ИТХ-ын өмнөх оны өглөг 0.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,359.6 сая төгрөг болж, тайлант оны үр дүнгийн хэмжээгээр 282.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	410.3	410.3	-
Хуримтлагдсан үр дүн	494.8	804.4	309.6
Өмнөх үеийн үр дүн	4,721.5	522.4	(4,199.1)
Тайлант үеийн үр дүн	(4,226.7)	282.0	4,508.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	172.4	144.8	(27.6)

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дүн	1,077.5	1,359.6	282.0
-----	---------	---------	-------

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Баяннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрт зориулан 2,025.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,573.7 сая төгрөгийг урсгал зардалд, 451.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,115.2 сая төгрөгийг улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр, 503.0 сая төгрөгийг сумын орон нутгийн төсвийн орлогын санхүүжилтээр, 287.4 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 120.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Баяннуур сум нь 2023 онд гүйцэтгэлээр нийтдээ 1,807.7 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлснээс улсын төсвөөс 1,115.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, сумын орон нутгийн төсвөөс 319.0 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 287.4 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 86.1 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой 141.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, оны эцэст орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс 42.2 сая төгрөгийг төвлөрүүлж, үндсэн үйл ажиллагааны орлого /Хоршоо хөгжүүлэх сан/ 53.8 сая төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,641.6 сая төгрөг буюу 81.0 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлого, эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс үндсэн үйл ажиллагааны орлогод 66.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, сумын ОНХС-гийн өмнөх оны төсвөөр худалдаж авсан тэжээлийг худалдсанаас туслах үйл ажиллагааны орлогод 19.9 сая төгрөгийн орлого оруулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 132 дугаар тогтоолоор Баяннуур сумын 2023 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 336.3 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 2023 оны 192 дугаар тодотголоор 345.5 сая төгрөгөөр буюу 9.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 52 дугаар хуралдааны тогтоолоор 2023 орлогын төлөвлөгөөг 345.5 сая төгрөгөөр хэвээр нь баталжээ. Мөн аудитын зөвлөмжийн дагуу сумын ИТХ-ын 2023 оны 51 дүгээр хуралдааны тогтоолоор малын тоо толгойн албан татварын төлөвлөгөөг 49.3 сая төгрөгөөр баталсан байна.

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Гүйцэтгэлээр сумын орон нутгийн төсвийн орлогод нийтдээ 387.9 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 7.5 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар тасарсан байна. Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татварын орлогоос ХХОАТ-ын буцаан олголтод 48.4 сая төгрөг олгосон байна.

Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
I.Татварын орлого	380.7	376.0	(4.7)	98.8
II.Татварын бус орлого	14.1	11.3	(2.7)	80.4
Нийт дүн	394.8	387.3	(7.5)	98.1

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Орон нутгийн орлого төлөвлөгөө тасрахад үйл ажиллагааны орлогын албан татвар 27.9 сая, үл хөдлөх хөрөнгийн татвар 1.9 сая, малд ногдуулах албан татвар 12.8 сая, улсын тэмдэгтийн хураамж 5.1 сая, ан амьтны нөөц ашигласны төлбөр 10.1 сая, газрын төлбөр 5.5 сая, хүү, торгуулийн орлого 2.7 сая төгрөгөөр тасарч, цалин хөлсний орлогоос 67.2 сая, хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар буюу хөрөнгийн орлого 10.6 сая, хөрөнгө борлуулсны орлого 0.8 сая, бууны албан татвар 0.7 сая, ойн нөөцийн төлбөр 1.6 сая төгрөгөөр давж биелэгдсэн нь орон нутгийн орлого бүрдүүлэхэд голлон нөлөөлсөн байна. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, хог хаягдлын хураамж 100 хувь тасарсан байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 20.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын дансуудаар 387.3 сая төгрөгийн татварын орлого оруулж, орон нутгийн төсвийн төвлөрүүлэлтийн орлогоос 43.7 сая төгрөгийн санхүүжилтийн орлого төвлөрч, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 91.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №3 Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлтийн талаар:

/сая төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХ	106.5	101.9	(4.6)
2	Сумын ЗДТГ	599.9	594.1	(5.8)
3	Ерөнхий боловсролын 1-р сургууль	484.4	466.9	(17.5)
4	Ерөнхий боловсролын 2-р сургууль	26.3	24.5	(1.8)
5	Ерөнхий боловсролын 3-р сургууль	16.5	15.5	(1.0)
6	Хүүхдийн цэцэрлэг	80.6	70.4	(10.2)
7	Соёлын төв	88.4	88.0	(0.4)
8	Эрүүл мэндийн төв	51.0	50.1	(0.9)
9	ОНХСан	451.9	330.0	(121.9)
10	СХС	120.0	66.2	(53.8)
	Нийт дүн	2,025.5	1,807.6	(217.9)

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Судалгаанаас харахад сумын ИТХ, ЗДТГ-ын төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан нь төсвийн зарлагын төлөвлөлттэй холбоотой байна. ОНХС, ХХС-гийн төсөв нь гүйцэтгэлтэй холбоотой бага гүйцэтгэлтэй гарчээ.

Боловсролын байгууллагууд 30.5 сая, Эрүүл мэндийн төв 0.9 сая, Соёлын төв 0.4 сая төгрөгөөр тогтмол зардлын төсвийг хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баяннуур сумын Засаг даргын тамгын газар нь 6.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч урамшуулалд 0.7 сая төгрөгийг, тээвэр шатахууны зардалд 3.4 сая төгрөгийг, шуудан холбооны зардалд 0.8 сая төгрөгийг зарцуулж, 1.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайланг 2024 оны 3 дүгээр сарын 05-ны өдрийн 01/51 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгө 1,101.5 сая төгрөгөөс 1.5

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

хувиар буюу 16.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сумын төсөв байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд үйл ажиллагаатай хамааралтай 2 шалгуурт алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад Засаг даргын захирамжаар тайлант онд төсөв, өмч, хөрөнгө зарцуулах холбоотой Хоршоо хөгжүүлэх сангаас 64.0 сая төгрөгийн зээл, Орон нутгийн хөгжлийн сангаас 139.9 сая төгрөгийн засаг даргын захирамжаар олгосон шийдвэрүүдийг шилэн дансанд байршуулаагүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 79.6%-тай байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална....”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ....” заасны дагуу мэдээллийг хугацаанд мэдээлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчид завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгдөөгүй байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар сумын Засаг дарга нарт “Малын татвараас орох орлогыг үндэслэлтэй төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулж, орлогыг сумын төсвийн орлогод бүрэн төвлөрүүлж ажиллах” талаар зөвлөмж өгөгдсөн байна. Баяннуур сумын ИТХ-ын 2023 оны 51 дүгээр хуралдааны тогтоолоор малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг 49.3 сая төгрөгөөр баталсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 2 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Ерөнхий боловсролын сургуулиуд, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвд орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 248.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 36.5 сая төгрөгийн залруулга хийгдэж, 88.1 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага, 123.5 сая төгрөгийн зөрчил¹ илэрч зөвлөмж өгөгдсөн.

Хүснэгт №4: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баяннуур сумын Засаг даргын тамгын газар	8	160.0	4	36.5					4	123.5
2	Баяннуур сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	-	-								
3	Баяннуур сумын ОНХСан	-	-								
4	Баяннуур сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	88.1					1	88.1		
Нийт дүн		9	248.1	4	36.5	-	-	1	88.1	4	123.5

Эх сурвалж: Аудитын зөрчлийн мэдээ

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 44.9 сая төгрөгийн алдаа² илэрч 44.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залрууллаа. Залруулсан алдаа:

- ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих орлогыг 5.6 сая төгрөгөөр дутуу тайлагнаж ирүүлсэн.
- Сумын 2023 оны орон нутгийн орлогын гүйцэтгэлийг хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар буюу хөрөнгийн орлогын гүйцэтгэлийг 38.4 сая төгрөгөөр буруу тайлагнасан, бусад нэр заагдаагүй орлогын гүйцэтгэлийг 0.8 сая төгрөгөөр илүү тайлагнаж ирүүлснийг тус тус залруулсан.

Аудитаар нийт 203.9 сая төгрөгийн зөрчил³ илэрч 2 заалттай зөвлөмж өгсөн.

1. Төлбөрийн акт

Акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад Засаг даргын захирамжаар төсөв, өмч, хөрөнгө зарцуулах холбоотой Хоршоо хөгжүүлэх сангаас 64.0 сая төгрөгийн зээл олгосон, Орон нутгийн хөгжлийн сангаас 139.9 сая төгрөг олгосон шийдвэрүүдийг шилэн дансанд байршуулаагүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 79.6%-тай байна.

Өгсөн зөвлөмж:

Засаг даргын захирамжаар Хоршоо хөгжүүлэх сангаас 64.0 сая төгрөгийн зээл олгосон, Орон нутгийн хөгжлийн сангаас 139.9 сая төгрөг олгосон шийдвэрийг шилэн дансанд нөхөн байршуулж зөрчлийг арилгах, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ....” заасны дагуу мэдээллийг хугацаанд мэдээлж ажиллах.

2. Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тодруулгатай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5-д зааснаар ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлтэй холбоотой тодруулга, танилцуулгыг иж бүрэн гаргаж ирүүлээгүй байна.

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Өгсөн зөвлөмж:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой тодруулга, танилцуулгыг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5-д зааснаар иж бүрэн гарган ирүүлж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үзүүлэлтийг үнэн зөв тайлагнаагүй	1	5,632.0			1	5,632.0	1	5,632.0				
Орон нутгийн орлогын гүйцэтгэлийн илүү тайлагнаж ирүүлсэн.	1	39,239.9			1	39,239.9	1	39,239.9				
Дүн	2	44,871.9			2	44,871.9	2	44,871.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тодруулга, танилцуулгыг иж бүрэн гаргаж ирүүлээгүй.	1	-					1	-				
Дүн	1	-					1	-				

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан шийдвэрийг шилэн дансанд байршуулаагүй	2	203,900.0					2	203,900.0
Дүн	2	203,900.0					2	203,900.0
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	2	203,900.0					2	203,900.0